



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Жаргалан өрхийн эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/001/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatarkhu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn
Аудитор: С.Оюунжаргал
Утас: 70432545 Цахим хаяг: Oyunjargals @audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	6
3.1 ЗӨВЛӨМЖ.....	6
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	8
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ.....	8

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нийцлийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.13 № 441
танай _____ -ны № _____ -г

ЖАРГАЛАНТ СУМЫН ЖАРГАЛАН ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ц.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь орон нутгийн өмч ашиглан зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр ажиллаж байгаа боловч эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг эрх бүхий этгээдээр батлуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар өрхийн эмнэлгийн барилгын өргөтгөлийн засвар 129,674.9 мянган төгрөгөөр, Жаргалант сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 14,540.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Эрүүл мэндийн газраас 5,419.1 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, байгууллагын төсвөөс 2,080.0 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч данс бүртгэлд бүртгэж, 32,784.7 мянган төгрөгийн 2000 оноос хойш данс бүртгэлт бүртгэлтэй 150 нэр төрлийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

8426050581
А4-Тоот-2026

Бусад асуудлын хэсэг

Тус өрхийн эрүүл мэндийн төв нь 2025 онд эрт илрүүлэг үзлэг оношилгоонд бусад өрхийн эрүүл мэндийн төвүүдээс 1 дүгээр байранд эрэмбэлэгдэж, Эрүүл мэндийн даатгалын газраас гэрээг 98.7 хувиар маш сайн үнэлгээтэй дүгнэн, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгээр 90 хувиас дээш хамрагдалт үзүүлсэн, магадлан итгэмжлэлийн эрхийг 3 жилийн хугацаагаар авсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	661,689.00	85,042.00
1.1.2	Дансны авлага	50,385,551.00	6,183,568.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	23,760.00
1.1.6	Бараа материал	30,514,630.00	24,927,873.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	81,561,870.00	31,220,243.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	234,042,043.00	357,263,980.00
1.2.2	Биет бус хөрөнгө	13,717,333.00	13,284,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	247,759,376.00	370,547,980.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	329,321,246.00	401,768,223.00
2.1.1.1	Дансны өглөг	2,674,907.00	8,461,234.00
2.1.1.2	Цалингийн өглөг	250,000.00	168,973.00
2.1.1.3	Татварын өр	0.00	346,652.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	7,475,392.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,400,299.00	8,976,859.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	10,400,299.00	8,976,859.00
2.3	Эздийн өмч	25,241,100.00	25,241,100.00
2.3.1	Өмч: - төрийн	18,253,820.00	18,253,820.00
2.3.2	- хувийн	6,987,280.00	6,987,280.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	13,381,300.00	13,381,300.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	176,993,100.00	176,993,100.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	103,305,447.00	177,175,864.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	318,920,947.00	392,791,364.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	329,321,246.00	401,768,223.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	451,114,573.00	535,533,688.00
3	Нийт ашиг (алдагдал)	451,114,573.00	535,533,688.00
8	Бусад орлого	42,705,309.00	166,820,758.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	463,379,583.00	595,699,323.00

Жаргалант сумын Жаргалан өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(32,784,706.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	30,440,299.00	73,870,417.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	30,440,299.00	73,870,417.00
24	Орлогын нийт дүн	30,440,299.00	73,870,417.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-ны үлдэгдэл	25,241,100	13,381,300	176,993,100	103,305,447	318,920,947
3	Залруулсан үлдэгдэл	25,241,100	13,381,300	176,993,100	103,305,447	318,920,947
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	25,241,100	13,381,300	176,993,100	103,305,447	318,920,947
11	Залруулсан үлдэгдэл	25,241,100	13,381,300	176,993,100	103,305,447	318,920,947
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	73,870,417	73,870,417
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	25,241,100	13,381,300	176,993,100	177,175,864	392,791,364

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	438,803,966.00	591,335,991.00
1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	59,938,500.00	159,431,850.00
	Татаас, санхүүжилтийн орлого	353,023,684.00	389,076,040.00
	Бусад мөнгөн орлого	25,841,782.00	42,828,101.00
	Мөнгөн зарлагын дүн (-)	437,312,135.00	589,832,638.00
1.3	Ажиллагчдад төлсөн	244,826,440.00	332,360,908.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	77,439,500.00	103,658,332.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	61,817,648.00	41,666,582.00
	Ашиглалтын зардалд төлсөн	1,604,752.00	3,922,696.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,355,167.00	5,967,000.00
	Татварын байгууллагад төлсөн	25,891,888.00	34,996,928.00
	Бусад мөнгөн зарлага	12,376,740.00	67,260,192.00
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,491,831.00	1,503,353.00

2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,200,000.00	2,080,000.00
2.3	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,200,000.00	2,080,000.00
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,200,000.00	2,080,000.00
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	359,358.00	(576,647.00)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	302,331.00	661,689.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	661,689.00	85,042.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулагдаагүй 866.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн 866.60 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

3.1 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тушаал шийдвэргүйгээр гүйцэтгэлийн үр дүнгээр мөнгөн урамшуулал олгосон, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга өөрөө өөртэй үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж Гүйцэтгэлийн үр дүнгийн урамшууллыг тушаал шийдвэрээр, өрхийн эрүүл мэндийн төвийн даргад олгох улирлын үр дүнгийн нэмэгдлийг дээд шатны байгууллагын удирдлагаар тушаал шийдвэр гаргуулан тус тус олгох.

3.1.2 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Рашаант өрхийн эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчийг гэрээт нягтлан бодогчоор ажиллуулахдаа төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, унаа хоол, амралтын цалинг давхар бодож олгосон нь 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2.Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.3-д Хуульд өөрөөр заагаагүй бол ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 15 өдөр байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн ажлаас гадуур давхар ажиллаж байгаа албан хаагчид цалин нэмэгдэл хөлсийг хууль тогтоомжид нийцүүлэн олгох

3.1.3 Бараа материалын зардалтай холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан зарим эмийг эмийн түүвэр, яаралтай тусламж, гэрийн эргэлтийн журналаас түүвэрлэхэд 866.60 мянган төгрөгийн 21ш Ветаплекс 500мл шингэн , 49ш Актовегин 40мг/5мл, эмийг илүү зарлагдсан дотоод хяналт хэрэгжүүлээгүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын зарцуулалтын анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлж, дотоод хяналтыг сайжруулан ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

(мянган төгрөгөөр)

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Жаргалан ӨЭМТ	Тушаал шийдвэргүй гүйцэтгэлийн урамшуулал олгосон, өөртөө үр дүнгийн урамшуулал олгосон	1						1			
	Эм, шингэн илүү зарлагдсан дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1	866.60					1	866.60		
	Цалингийн нэмэгдэл давхардуулж олгосон	1						1			
Нийт дүн		3	866.60						866.60		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			